

Олон улсын байдлын нааштай өөрчлөлтийг угтуулан 1988 онд дэвшүүлсэн БНСУ-ын умардын бодлого үндэснийх нь аюулгүй байдлыг хамарсан улс төр, эдийн засгийн дараах үндсэн зорилтуудыг агуулсан юм. Үүнд, нэгдүгээрт: тэр үеийн социалист гэгдэж байсан орнууд ялангуяа ЗХУ (хуучин), БНХАУ-тай төрийн харилцаа тогтоох, чингэснээр олон улсын байр сууриа бэхжүүлэх, солонгосын хойгийн аюулгүй байдлыг тогтворжуулах, БНАСАУ-ыг нээлттэй бодлого, өөрчлөлт шинэчлэлд хамруулах энэ бүхний үндсэн дээр хуваагдмал үндэстнээ нэгтгэхэд чиглэсэн гадаад таатай нөхцөл бүрдүүлэх; хоёрдугаарт: мөн эл зорилгоор солонгосын умард, өмнөд хэсгийн хоорондын яриа хэлэлцээ, хэлхээ холбоог өргөжүүлэн урагшлуулах, гуравдугаарт: экспортын чиглэл тэргүүлсэн бүтэцтэй эдийн засгийн хүч чадавхаа нэмэгдүүлэх шинэ нөөц боломж олж авах явдал байв.

**Нэг. Солонгосын хойгийн гадаад орчин  
нөхцөл**

Улс хоорондын харилцаанд нэгдмэл хийгээд олон талт шинэ дэг журам тогтож буй; цөмийн дайны аюул багасч эвлэрэл итгэлцэл, хамтын ажиллагаа давамгайлж байгаа; асуудлыг цэрэг, улс төрийн хүчээр шийдвэрлэдэг байсан хуучин арга эдийн засгийн нөлөөлөлөөр солигдож байгаа; зах зээлийн эдийн засаг, чөлөөт худалдаагаар дамжин, нээлттэй бодлого улам бүр түгээмэлжих хандлага идэвхжиж буй зэрэг олон улсын амьдралд гарч буй шинэ онцлог шинж байдлууд БНСУ-ын гадаад бодлого, түүний бүрэлдэхүүн хэсэг болсон умардын бодлогын хэрэгжилтэнд аятай нөлөө үзүүлж ирсэн бөгөөд үзүүлсээр байна.

Ялангуяа тус улсын оршин буй Зүүн Хойд Азийн (ЗХА) улс төрийн тогтвортой байдал, энэ бүс нутгийн олон талт хамтын ажиллагааны найдвартай нөхцөл нь БНСУ-ын хувьд онцгой чухал ач холбогдолтой юм. Учир нь тус улсын гадаад улс төрийн бодлого амжилттай хэрэгжих эсэхийг шийдвэрлэх хүчин зүйлийн нэг нь энэ бүс нутгийн уур амьсгалаас ихээхэн шалтгаалахад оршино. Ийм ч учраас солонгосын хойгийн асуудалд үзүүлэх шууд болон дам нөлөөгөөр төдийгүй ЗХА-ийн тогтвортой байдал, хамтын ажиллагаанд чухал үүрэгтэй Хятад, Орос, Япон, АНУ-тай харилцах харилцаа БНСУ-ын гадаад бодлогод онцгой чухал байр суурь эзэлж, тус улсын гадаад бодлого дээр дурдсан олон улсын үйл амьдрал дахь өөрчлөлтийн түгээмэл шинжийн хүрээнд тэгэхдээ энэ бүс нутгийн онцлогт нийцэн зохицуулагдаж байна.

ЗХА-ийн байдлын тухайд гэвэл, АНУ Ази, Номхон далай дахь зэвсэгт хүчнээ хорогдуулах, цэргийн зардлын зарим хэсгийг байрлаж буй орноор даалгах г.м. асуудал хөндөгдөж буй боловч бүхэлд нь авч үзэхэд энэ бүс нутаг дахь АНУ-ын үүрэг, нөлөө урьдын адил давамгайлах шинжтэй хэвээр байх бололтой. Солонгосын хойгийн асуудал, түүний дотор энэ хойг дахь америкийн зэвсэгт хүчний талаарх аме-

\*Дорно дахин, олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

рикийн шинэ засаг захиргааны байр сууринд ноцтой өөрчлөлт гарахгүй төлөв харагдаж байна.

Эдийн засгийн хүч чадлын цар хүрээнд тулгуурласан Японы нөлөө ЗХА-д улам өргөжих чиглэлээр идэвхжиж байна.

Дотоод улс төр, эдийн засгийн байдал, зорилтоос шалтгаалан Хятад, Оросын цэрэг улс төрийн нөлөө одоогоор энэ бүс нутагт сул байгаа хэдий ч тус хоёр орны дотоод байдал тогтворгүйтвэл түүнээс үүдэн гарах үр дагавар энэ бүс нутгийн байдалд ноцтой нөлөөлнө гэдгийг бусад улсын нэгэн адил БНСУ гадаад бодлогодоо ихээхэн харгалзаж үзэх учиртай болж байна.

Бүс нутгийнхаа улс төрийн энэ байдлыг харгалзан БНСУ АНУ-тай харилцах харилцаанд тэргүүн зэргийн ач холбогдол өгч байна. Тус хоёр орны харилцаа урьдын адил хэвийн үргэлжилж байгаа бөгөөд цэрэг улс төрийн салбарт Ази, Номхон далайн сав газар, ЗХА-ийн стратегийн ерөнхий чиг шугамд нийцүүлсэн нэгдмэл бодлого баримталж байна. Эдийн засгийн хувьд АНУ урьдын адил БНСУ-ын хамгийн том зах зээл болсон хэвээр байна. АНУ-ын ерөнхийлөгч Билл Клинтон 1993 оны VI сард БНСУ-д айлчлах бололтой.

БНСУ, Японы найрсаг хөршийн харилцаа 1991 оны эхээр дээд хэмжээнд тохиролцсон хамтын ажиллагааны гол зарчмуудад тулгуурлан бэхжиж, худалдааны тэнцвэрт бус байдлыг зохицуулах, харилцаанд сөрөг нөлөө үзүүлж ирсэн өнгөрсөн түүхэн нөхцөл байдлын талаар харилцан ойлголцсон, зөв үнэлэлт дүгнэлтэнд хүрэх арга замыг эрэлхийлж байна. АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн дараахан 1992 оны XI сард болсон БНСУ, Японы дээд хэмжээний уулзалтаар хоёр тал олон улсын асуудлаархи байр сууриа илэрхийлж XXI зууныг угтуулсан «ирээдүй өөд чиглэсэн бүтээлч хамтын ажиллагаа»<sup>1</sup> хөгжүүлэхээр тохиролцов.

БНАСАУ цөмийн зэвсгийн байгууламж бүтээн боловсруулах нь солонгосын хойгоор тогтохгүй ЗХА-ийн бүс нутгийн аюулгүй байдалд ноцтой аюул занал учруулах талаар АНУ, Япон нэгдмэл байр суурь баримталж энэ ажлын үйл явцыг Умард, Өмнөд Солонгос харилцан шалгах тухай БНСУ-ын саналыг эдгээр орнууд дэмжиж байна.

БНХАУ-тай 1992 онд дипломат харилцаа тогтоосон явдал БНСУ-ын гадаад бодлогын чухал амжилт, хоёр орны харилцааны түүхэнд шинэ хуудас нээсэн томоохон үйл явдал болов. Умардын бодлогынх нь эхний шатны амжилтын төгсгөл болсон энэ үйл явдалд БНСУ хэр зэрэг ач холбогдол өгснийг харилцаа тогтоомогц сарын дараа БНСУ-ын ерөнхийлөгч Хятадад айлчилсан явдал харуулсан бөгөөд энэ үеэр хоёр орны засгийн газар хооронд худалдаа, шинжлэх ухаан техник, соёлын хамтын ажиллагааны болон хөрөнгө оруулалтын холбогдолтой 4 хэлэлцээр байгуулав.

БНСУ олон жилийн түнш Тайваньтай харилцаагаа тасалж, БНХАУ уламжлалт ойр дотно харилцаатай явж ирсэн БНАСАУ-ын хүсэлтийг талаар болгон өөр хоорондоо ийнхүү төрийн харилцаа тогтооход хүргэсэн уг сурвалж бол өнөөгийн бодит нөхцөл байдлыг харгалзсан хэн хэнийх нь үндэсний эрх ашгийн сонирхол байв.

БНСУ-ын хувьд БНХАУ-ын олон улс, бүс нутгийн хүрээнд эзлэх байр суурийн жин, солонгосын асуудлыг шийдвэрлэхэд гүйцэтгэх үүрэг нөлөө, эдийн засгийн хамтын ажиллагааны боломж цар хүрээ, өргөн уудам зах зээл, харилцааны цаашдын төлөв зэрэг олон хүчин зүйлийг харгалзсаны дотор хамгийн гол нь солонгосын асуудлыг шийдвэрлэх, солонгосын хойгийн улс төрийн тогтвортой байдлыг сахин хамгаалахад БНХАУ-тай харилцаа тогтоох нь онцгой ач холбогдолтой байв. БНАСАУ-ыг нээлттэй бодлого, өөрчлөлтөд татан оруулах талаар БНХАУ шууд даралт шахалт үзүүлдэггүй юмаа гэхэд солонгосын хоёр

хэсгийн хооронд наанадаж тэнцвэртэй байр суурь баримтлах нь хүчний харьцаанд ашигтай нь мэдээж.

Эдийн засгийн шинэчлэлийн бодлогоо тэлэн эрчимжүүлэх гадаад илүү таатай нөхцөл бүрдүүлэх, БНСУ-ын өөрийнх нь хөрөнгө, техник технологи болон тус улсаар дамжуулж олон улсын байгууллагаас оруулах дэмжлэг тусламжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн Хятадын эрмэлзэл; Тайваны гадаад харилцааны сүүлийн үеийн идэвхжил; Хятад-Америк, Хятад-Японы харилцаа зэрэг асуудал таамаглаж байсан хугацаанаас өмнө БНСУ-тай харилцаа тогтооход БНХАУ-д түлхэц өгсөн гэж үзэж болох байна. Солонгосын хойгийн тогтвортой байдал ч Хятадын эрх ашигт нийцэх нь тодорхой. Тус хоёр орны харилцаа худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техник, соёл, иргэний үйлдвэрийн чиглэлээр улам өргөжих хандлагатай байгаа бөгөөд зөвхөн худалдааны нийт дүнг нь аваад үзэхэд 1989 онд 3,1 тэрбум байснаа 1991 онд 5,8 тэрбум долларт хүрсэн<sup>2</sup> бөгөөд ойрын хэдэн жилд 10 тэрбум доллар болж өсөх төлөвтэй байна. Одоогийн байдлаар Хятад БНСУ-ын худалдааны дөрөвдэх, БНСУ Хятадын долоо дахь түнш болоод байна.

1990 оны IX сард дипломат харилцаа тогтоон дээд хэмжээний хэд хэдэн уулзалтаас нилээд идэвхжиж ирсэн БНСУ, Орос улсын харилцааг 1992 оны XI сард хийсэн ерөнхийлөгч Б. Ельциний айлчлал улам бататгалаа. Айлчлалын үеэр БНСУ, Оросын үндсэн харилцааны гэрээ байгуулж, соёл, гаалийн хамтын ажиллагааны хэлэлцээр, давхар татвараас чөлөөлөх протоколд гарын үсэг зурав. Мөн энэ үеэр худалдааны саад бэрхшээлийг арилгах, өмнө нь тохирсон хамтын ажиллагааны 74 төслийг хэрэгжүүлэх, ШУТ-ийн хамтын ажиллагааны хоёр тал дахь төвийн үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих, харилцаа холбооны чиглэлд хамтарч ажиллахаар тохиролцсоны дээр Сибирь, Алс Дорнод, Сахалины нефть, хий, байгалийн бусад баялгийг хайн олборлох, Находкийн эдийн засгийн чөлөөт бүст БНСУ-ын хөрөнгийг оруулах, автомашин, цахилгаан болон электрон тоног төхөөрөмж, хими, өнгөт металл, хөлөг онгоц, нийлэг эдлэлийн ба сансрын судалгаа шинжилгээний чиглэлээр хамтран ажиллах боломж нөөцийг ашиглах асуудал голлон ярилцсан байна. Б. Ельцин айлчлалтайгаа холбогдуулж хийсэн хэвлэлийн бага хурал дээр Орос Улс БНАСАУ-д цөмийн төхөөрөмж материал, цөмийн судалгааны хэрэгсэл, байлдааны нисэх онгоц нийлүүлэхээ зогсоосон, цаашид хуучин ЗХУ, БНАСАУ-ын найрамдал хамтын ажиллагаа, харилцан туслах тухай гэрээний цэргийн тусламж үзүүлэх агуулга бүхий хэсгийг хүчингүй болгох зэргээр уг гэрээнд ихээхэн засвар хийх<sup>3</sup> тухайгаа мэдэгдэв. Оросын энэ байр суурь Хятад, БНАСАУ-ын гэрээг дахин эргэж үзэхэд хүргэж болох юм. БНСУ тусгаар тогтносон хамтын нөхөрлөлийн 11 оронтой дипломат харилцаа тогтоон зарим чиглэлээр харилцаагаа өргөтгөхөөр төлөвлөж байна.

Умардын бодлогын хугацаанд БНСУ-ын олон улсын байр суурь мэдэгдэхүйц өндөржиж 1991 онд НҮБ-ын гишүүнээр элсэж эдүгээ 166 оронтой төрийн харилцаатай, НҮБ-ын болон олон улсын бусад 20 гаруй байгууллагын гишүүнээр ажиллаж байна.

Зэвсэглэлийг хорогдуулах, хүний эрхийг хамгаалах, олон улсын шинжтэй алан хядлага, өдөөн хатгалагын эсрэг тэмцэх, хүрээлэн буй орчныг хамгаалах, буурай хөгжилтэй орнуудад туслах, олон улсын байгууллага, сайн дурын фондыг санхүүжүүлэх, НҮБ-ын энх тайвныг сахиулах хүчний үйл ажиллагаанд оролцох зэрэг дэлхийн хамтын нийгэмлэгийн хүрээнд оролцох тус улсын оролцоо, үүрэг нь нэр хүнд, эдийн засгийн чадавхийн өсөлтийнхөө хирээр өндөржиж байна.

## **Хоёр. Умард, өмнөдийн яриа хэлцээ хэлхээ холбоо**

Умардын бодлогын гол чиглэлийн нэг болсон солонгосын хоёр хэсгийн хоорондын яриа хэлцээ, хэлхээ холбоонд урьд өмнөх үеэс илүү тодорхой ахиц гарч байна. Ерөнхий сайд нарын хэд хэдэн уулзалтын дүнд эвлэрэх, хамтран ажиллах шинэ үеийг нээсэн тохиролцоонд 1991 онд хүрч, Солонгосын хойгийг цөмийн зэвсэггүй бүс болгох хамтарсан тунхаглал гарган дээрх тохиролцоог хэрэгжүүлэх салбар комиссууд байгуулагдаад байна. Хоёр хэсгийн хооронд шууд худалдаа, эдийн засгийн хэлхээ холбоо өргөжиж буй нь тэмдэглүүштэй хэрэг юм. 1992 оны IX сарын байдлаар хоёр талын худалдаа, эдийн засгийн солилцооны нийт дүн 187 сая долларт хүрснээр<sup>4</sup> БНСУ нь БНАСАУ-ын гадаад худалдааны дөрөвдэх түнш болж, БНАСАУ-ын баруун далайн Нампо боомт зэрэг умард солонгосын эдийн засгийн зарим барилга байгууламжид БНСУ-ын хөрөнгө оруулж хамтарсан үйлдвэр аж ахуйн газар байгуулах асуудал хөндөгдөж байна.

Хоёр талын хэлхээ холбоонд саад тотгор учруулах буй гол асуудал БНАСАУ-ын цөмийн тоног төхөөрөмжийн асуудал болж байгаа бөгөөд мөн төрөл төрөгсөдийг харилцан зочлуулах асуудалд ахиц гарахгүй байна. Тухайн үеийн байдлаас шалтгаалан хоёр талын яриа хэлцээ, хэлхээ холбоо түр зуур саатаж байгаа ч гэсэн бүхэлд нь авч үзэхэд нааштай ахиц, алхмууд гарч байна гэж үзэх бүрэн үндэстэй юм.

Дээрх хоёр чиглэлээр авсан арга хэмжээ, олсон ололт амжилтыг умардын бодлогын гол үр дүн, солонгосын хойгийн эргэн тойрон хийгээд хойгт гарч буй үндсэн өөрчлөлт гэж үнэлж болох байна.

Ноён Ро Дэ У ерөнхийлөгчийн үедээ 1992 оны XI сард Умардын бодлогын дүнгийн тухай тайлан хурал дээр «... Бид одоо үндэсний нэгдлийн үйл явцад тулж ирлээ ... Энэ зууны дотор Өмнөд, Умардын нэгдэл хэрэгжинэ гэдэгт итгэж байна . . .»<sup>5</sup> гээд үндэстнээ нэгтгэх нийгэм, эдийн засгийн хангалттай бэлтгэлтэй байхыг анхааруулав. Мөн уг хуралд Гадаад эдийн засгийн бодлого судлах хүрээлэнгээс оруулсан илтгэлд «. . . нэгдмэл улсын хүн ам 2010 онд 78 сая, үндэсний нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ 1125 тэрбум долларт хүрч дэлхийн эдийн засгийн 10 гүрний эгнээнд орно»<sup>6</sup> гэж тэмдэглэжээ.

### **Гурав. БНСУ-ын гадаад бодлогын цаашдын чиглэл**

Үндэстнээ нэгтгэх тулгамдсан зорилт, газарзүйн байрлал, бүс нутгийн хамтын ажиллагааны хэрэгцээ шаардлага, бололцоо зэрэг нөхцөл шалтгаануудаас үүдэн БНСУ-ын гадаад бодлого, хамтын ажиллагааны үндсэн чиглэл ЗХА руу илүү чиглэгдэх нь тодорхой байна. Үүний тулд бүс нутгийн орнууд болон уламжлалт харилцаатай АНУ-тай хамтран ажиллаж, үйл ажиллагаагаа зохицуулахыг чухалчилж байна. Ноён Ро Дэ У ерөнхийлөгч байхдаа НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 47-р чуулганд 1992 оны IX сард хэлсэн үгэндээ ЗХА-д энх тайван шинэ дэг журам тогтоох зорилгоор бүс нутгийн орнуудын яриа хэлэлцээ хийх<sup>7</sup> санал дэвшүүлсэн нь үүний нэг илрэл мөн.

Тус улсын гадаад бодлогын бас нэг гол чиглэл нь үндэстнээ нэгтгэх нөхцөл бололцоог бүрдүүлж уг зорилтоо аль болох ойрын хугацаанд бүрэн хэрэгжүүлэхэд чиглэж байна. Чингэхдээ асуудлыг шууд холбогдох талууд шийдвэрлэх, үндэсний аюулгүй байдлын найдвартай баталгааг хангах, нийт солонгос үндэстний нийтлэг эрх ашигт нийцүүлэх гэсэн гол гурван зарчмын үндсэн дээр шийдвэрлэх чиг шугам баримталж байна. Дэлхий нийтийг хамарсан өөрчлөлт, нээлттэй бодлогын урсгалд оролцох таатай нөхцөлийг БНАСАУ-д олгох, солонгосын хоёр хэсгийн яриа хэлцээ, хэлхээ холбоо, хамтын ажиллагааны

бодит үр өгөөжийг нэмэгдүүлэх нь учир зүйд нийцнэ гэдгийг БНСУ сайтар харгалзаж байгаа бололтой. Ер нь солонгос үндэстэн нэгдэхээс өмнө одооноос БНАСАУ-ыг олон улс, бүс нутгийн хамтын ажиллагаанд өргөн хүрээтэй хамран оролцуулах нь зөвхөн БНАСАУ-ын төдийгүй нийт солонгос үндэстний ирээдүйн эрх ашигт нийцэх нь дамжиггүй юм.

Дараачийн өөр нэг чиглэл Ази, Номхон далайн болон ЗХА-ийн эдийн засгийн хамтын ажиллагаанд аль болох үр нөлөөтэй оролцох явдал мөн ажээ. Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд олон улсын дунд эзлэх БНСУ-ын байр суурь нилээд өвөрмөц сонин байгаа нь анхаарал татахгүй байж болохгүй мэт. Тус улс буурай хөгжлөөс хөгжингүй орны түвшинд хүрэхийн өмнөх өөрөөр хэлбэл энэ хоёр үе шатын зааг дээр байгаагаараа онцлогтой юм.

#### АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖУУД

1. Хангук Илбо сонин, 1992.11.9 № 13719
2. «БНСУ-ын гадаад бодлогын тэргүүн зорилт бол Зүүн Хойд Азид энх тайван байдал тогтворжуулах явдал мөн», Шинэ Дон А сэтгүүл. 1992 он, № 9, 129-р тал
3. Хангук Илбо сонин, 1992. 11.21 № 13731
4. Пак Вон Син, «Өмнөд, Умардын эдийн засгийн солилцоо ямар шатанд хүрээд байна вэ?» Пукхан сэтгүүл, 1992 он, № 9, 24-р тал
5. Сеул сонин, 1992.11 .25 № 14874
6. —
7. Чосен илбо сонин, 1992.9.23 № 22117